



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

┌ Албан тушаалын цалингийн хэмжээг ┐
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоол, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 225 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал /ТҮЭМ/-ын цалингийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал /ТҮ/-ын цалингийн доод хэмжээгээр цалинждаг эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилтнуудын үндсэн цалингийн хэмжээг хоёрдугаар, төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаал /ТҮМ/-ын цалингийн доод хэмжээгээр цалинждаг эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилтнуудын үндсэн цалингийн хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг батлагдсан төсөвтөө багтаан нэмэгдүүлж, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан нэмэгдлийг тооцохдоо Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг баримтлахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3. Төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллагуудын төсөв болон сар, улирлын хуваарьт холбогдох өөрчлөлтийг оруулан батлуулахыг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газар (Л.Мөнхцэцэг)-т, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, төлбөрийн хэмжээ, журамд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу зохих өөрчлөлт оруулж хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалтын газар (Д.Отгонбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, сул орон тоонд албан хаагч нөхөж авахгүй байх, ажлын гүйцэтгэл үр дүн бүтээмжийг нэмэгдүүлэх,

141260092

зарим үйл ажиллагааг цахимжуулах замаар байгууллагын үр ашгийг сайжруулах арга хэмжээг авч ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаалыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлсүгэй.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 01
дүгээр сарын 14-ны өдрийн 0.4/1 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТҮЭМ-9	2,346,500
ТҮЭМ-8	2,233,400
ТҮЭМ-7	2,128,100
ТҮЭМ-6	2,026,700
ТҮЭМ-5	1,929,200
ТҮЭМ-4 Резидент эмчээс бусад	1,838,200
ТҮЭМ-4 Резидент эмч	969,000
ТҮЭМ-3	1,751,100
ТҮЭМ-2	1,667,900
ТҮЭМ-1	1,515,800

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн АМ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт




ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН
ДООД ХЭМЖЭЭГЭЭР ЦАЛИНЖДАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН
ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТҮ-12	2,345,200
ТҮ-11	2,233,400
ТҮ-10	2,126,800
ТҮ-9	2,025,400
ТҮ-8	1,842,100
ТҮ-7	1,742,000
ТҮ-6	1,658,800
ТҮ-5	1,508,000
ТҮ-4	1,436,500
ТҮ-3	1,367,600
ТҮ-2	1,303,900
ТҮ-1	1,240,200

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 01
дүгээр сарын 11-ны өдрийн 111 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БУСАД
БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН
ДООД ХЭМЖЭЭГЭЭР ЦАЛИНЖДАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН
ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТҮМ-7	2,026,700
ТҮМ-6	1,929,200
ТҮМ-5	1,838,200
ТҮМ-4	1,751,100
ТҮМ-3	1,667,900
ТҮМ-2	1,515,800
ТҮМ-1	1,378,000